

Шалгалтын дүнгийн тухай

Нэг. Шалгалтын зорилго

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын албаны 2023 оны нэгдсэн төлөвлөгөө, Сангийн сайдын 2023 оны сарын 03 дугаар сарын 23-ны өдрийн СХШХ/02 тоот удирдамжийн дагуу аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оноос 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомж түүнийг үндэслэн Төрийн эрх бүхий байгууллагаас нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон дүрэм, журам, стандартын биелэлт, хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, санал дүгнэлт гаргах замаар эсрдлийг бууруулж ажиллахад шалгалтын зорилго чиглэгдэв.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн хугацаа:

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Т.Цэрэгбаяр ахалж, Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч, дотоод аудитор Д.Оюунсүрэн, Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч, дотоод аудитор Б.Чулуунбат нар 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс ажлын 20 хоногт хийж гүйцэтгэлээ.

Гурав. Шалгалтад хамрагдсан асуудлууд:

Шалгалтад 2021, 2022 оны даргын тушаал, дотоод журам, сангуудын үндсэн баримтууд, тайлан тэнцлүүд, анхан шатны баримтууд хамрагдлаа.

Дөрөв. Шалгалтад хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл:

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 1200 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй, 9051341 тоот регистрийн дугаартай, Баруун-Урт сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэрт оршдог, нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн биелэлтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих, ажил олгогч, даатгуулагч иргэдийг нийгмийн даатгалд хамруулах, нийгмийн

даатгалын санг бүрдүүлэх, уг сангаас даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр тогтоон олгох ажлыг эрхлэн зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэйгээр удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 29 үйлчилгээний 6 нийт 35 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна. Хөрөнгө мөнгө захиран зарцуулалтыг авч үзвэл:

№	Байгууллагын нэр	Харилцах данс, банкны нэр	1 дүгээр гарын үсгийг	2 дугаар гарын үсгийг
1	Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс	ТСНД 100120090010	П.Амар 2021.01.01-2022.12.31	Т.Сайнжаргал 2021.01.01-2021.12.31 Батболд 2022.05.01-2022.12.31
2	Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс /нэмэлт санхүүжилт/	ТСНД 1001200900401		
3	Аймгийн Тэтгэвэрийн даатгалын сан	100120090001		
4	Тэтгэмжийн даатгалын сан	100120090002		
5	ҮОМШӨ-ийн даатгалын сан	100120090004		
6	Ажилгүйдлийн даатгалын сан	100120090005		
7	Эрүүл мэндийн даатгалын сан	100120090003		

Тав: Өмнөх шалгалтын талаар:

1. Аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба 2019 онд 2017, 2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 34445.9 мянган төгрөгийн 2 салбар акт тогтоосныг барагдуулсан байна.

2. Аймгийн Аудитын газар 2022 онд 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж, зөрчилгүй санал дүгнэлт өгч, 2 заалт бүхий зөвлөмж өгснөөс 1 заалтыг нь хэрэгжүүлсэн байна. 2023 онд 2022 оны үйл ажиллагаанд аудит хийж, өөрчлөлтгүй дүгнэлт өгсөн байна.

Түүнчлэн аймгийн Мэргэжлийн хяналтын газраас мөн онд 2022 онд 2020-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийж, 7 тэтгэвэр авагчдад илүү олгосон 3465.1 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх, нэр бүхий 16 тэтгэвэр авагчдад дутуу олгосон 3059.1 мянган төгрөгийг тэтгэвэр авагчдад нөхөн олгуулахаар, нийгмийн даатгалын 2 ажилтанд дутуу олгосон 260.5 мянган төгрөгийн зөрчилд 4 салбар акт, 16 заалт бүхий 2 албан шаардалага тус тус тогтоосныг барагдуулсан байна.

3. Тус хэлтсийн Хяналт шалгалт дотоод аудитын тасаг нь 2021 онд аймгийн хэмжээнд 166 ААНБ-ын шимтгэл төлөлт тайлагналтын хуулийн хэрэгжилтийг шалгахаар төлөвлөсөн бөгөөд Ковид-19 цар тахал өвчин гарсантай холбогдуулан хяналт шалгалтын ажлыг түр зогсоосон ч зарим нэгжүүдэд хяналт хийж шалгалтаар илэрсэн даатгуулагчийн ажилгүйдлийн тэтгэмжийг илүү олгосон 1204.6 мянган төгрөгийн актыг үйлдсэн байна.

4. Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 2022 оны 04 дүгээр сард 2017-2021 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, тэтгэвэрийн даатгалын сангаас 25 иргэнд 4.8 сая төгрөгийг илүү олгосон зөрчилд акт тогтоож, тэтгэвэр тэтгэмжийн тогтоолт, олголтод

хяналт тавих, тэтгэвэрийн хувийн хэргийг цэгцэлж, массивын дагуу тооллого хийх, зарим сумдын байцаагч нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулах зэрэг зөрчлүүдэд зөвлөмж өгсөн байна.

Зургаа. Шалгалтын явцад хийгдсэн ажил, шийдвэрлэсэн асуудал:

-Тухайн байгууллагын орлогын төлөвлөлт, төвлөрүүлэлт, төсөвт байгууллагын хөрөнгийн зарцуулалтад хяналт шалгалт хийхэд:

Үндсэн үйл ажиллагааны талаар:

2021 онд улсын төсвөөс 551907.9 мянган төгрөгийн, нэмэлт санхүүжилтийн дансанд 6437.5 мянган төгрөгийн нийт 558345.4 мянган төгрөгийн эх үүсвэртэй, 544422.6 мянган төгрөгийн зардал гаргаж, 7485.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн, 2022 онд улсын төсвөөс 623767.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, 607382.4 мянган төгрөгийн зардал гаргаж, 16385.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Зардлыг ангиллаар харуулбал: 2021 онд цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардалд 400181.0 мянган төгрөг, 2022 онд 425339.7 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 2021 онд 52909.8 мянган төгрөг, 2022 онд 52979.4 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 2021 онд 37420.8 мянган төгрөг, 2022 онд 37905.0 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 2021 онд 19359.9 мянган төгрөг, 2022 онд 15933.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардал 2021 онд 2498.4 мянган төгрөг, 2022 онд 2374.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 2021 онд 2499.7 мянган төгрөг, 2022 онд 6358.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 2021 онд 13403.0 мянган төгрөг, 2022 онд 7091.8 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 2021 онд 2000.0 мянган төгрөг, 2022 онд 1900.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 14216.4 мянган төгрөг, 2022 онд тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж 51808.1 мянган төгрөг тус тус зарцуулсан байна. 2022 онд цалингийн зардал 6843.3 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардал 4387.1 мянган төгрөгөөр бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 2374.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Нэмэлт орлогын дансанд 2021 онд Ерөнхий газраас сургалтын зардалд 285.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газраас шагналын 3000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын нөөц сангаас А/185 тоот захирамжийн дагуу 3152.5 мянган төгрөг тус тус төвлөрч, засварын зардалд 3152.5 мянган төгрөг, материалын зардалд 285.0 мянган төгрөг, шагналын зардалд 3000.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

-Өр авлагын барагдуулалт, үүссэн өр авлагыг данс бүртгэлд бүрэн тусгасан эсэх:

Тус Нийгмийн даатгалын хэлтэсийн үйл ажиллагаа нь 2022 онд 71.6 мянган төгрөгийн шимтгэлийн өглөгтэй илэрхийлэгдсэн байна.

- Бараа материал, эргэлтийн хөрөнгийн хөрөнгийн хөрөнгийн талаар:

Бараа материалын эхний үлдэгдэл 2021 онд 22289.7 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 15462.1 мянган төгрөг буюу 2965.4 мянган төгрөгийн материалын үлдэгдэлтэй болж өссөн, 2022 онд эцсийн үлдэгдэл 95.8 мянган төгрөгийн материалын үлдэгдэлтэй буурсан байна.

/мян.төгрөгөөр/

Үзүүлэлт	2021 он			2022 он		
	Эхний/үлд	Эцсийн/үлд	Өсөлт/+/ Бууралт/-/	Эхний/үлд	Эцсийн/үлд	Өсөлт/+/ Бууралт/-/
Бичиг хэргийн /мат	1088.1	3594.3	2506.2	3594.3	2865.5	-728.8
Аж ахуйн материал	11408.6	10572.2	-836.4	10572.2	11232.7	660.5
Сэлбэг хэрэгсэл	-	-	-	-	251.2	251.2
Түлш шатахуун	-	-	-	-	-	-
Бусад хангамжийн /мат		1295.6	1295.6	1295.6	1208.5	-87.1
Нийт дүн	22289.7	15462.1	2965.4	15462.1	15557.9	95.8

-Үндсэн ба эргэлтийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, зарцуулалтын байдал, тооллого үнэн зөв чанартай хийгдсэн эсэх:

/Мянган төгрөгөөр /

	Балансын зүйл	2021 он			2022 он		
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
1	Барилга/байгууламж	454927.8	454927.8	-	454927.8	454927.8	-
2	Тоног төхөөрөмж	122947.2	69030.9	-567083.7	69030.9	91245.9	-22215.0
3	Авто тээврийн /х	69900.0	69900.0	-	69900.0	10485.0	59415.0
4	Тавилга эд хогшил	75273.9	74889.9	384.0	74889.9	18036.8	56853.1
5	Бусад үндсэн хөрөнгө	5000.0	5000.0	-	5000.0	5000.0	-
6	Биет бус хөрөнгө	17328.0	17328.0	-	17328.0	17328.0	*-
	ДҮН	745376.9	691076.7	54300.2	691076.7	597023.5	94053.2

2021 онд Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 2480.0 мянган төгрөгийн Кеско төхөөрөмж хөрөнгө оруулсаныг, Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2021 оны 12 сарын 30-ны өдрийн а/180 тоот тушаалаар 630.9 мянган төгрөгийн 6 ширхэг тог баригч, 5107.2 мянган төгрөгийн 4 ширхэг компьютер, 737.8 мянган төгрөгийн 8 ширхэг тог баригч тус тус акталсныг данс бүртгэлд тусгасан байна.

2022 онд Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 542.2 мянган төгрөгийн олон үйлдэлт хэвлэгч, 4246.0 мянган төгрөгийн хувилагч, 2035.0 мянган төгрөгийн скайер,

5390.0 мянган төгрөгийн 7 ширхэг олон үйлдэлт хэвлэгч, 1650.0 мянган төгрөгийн 3 ширхэг лазер хэвлэгч, 12003.6 мянган төгрөгийн 6 ширхэг зөөврийн компьютер зэрэг 64855.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хөрөнгө оруулсаныг, өөрийн хөрөнгөөр 441.5 мянган төгрөгийн дулааны тоолуур худалдаж авсныг данс бүртгэлдээ тусгасан байна. Нийгмийн даатгалын Ерөнхий газрын 2022 оны 12 сарын 31-ний А/193 тоот тушаалаар 3063.0 мянган төгрөгийн ширээ сандал акталсныг данс бүртгэлдээ тусгажээ.

Сангуудын орлого төлөвлөлтийн талаар:

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 8.4.1, Нийгмийн даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалтын дагуу 2021, 2022 онд нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг ажлын хэсэг байгуулан батлагдсан маягт зааврын дагуу боловсруулж холбогдох газарт хүргүүлсэн байна.

/мян.төг/

Үзүүлэлт	2021 он				2022 он			
	Төсвийн төсөлд өгсөн санал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төсвийн төсөлд өгсөн санал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогчийн төлөх шимтгэл	3306649	27113881.7	3758788.9	-1044907.2	3385946.0	7125952.5	4518056.7	2607895.8
Даатгуулагчийн төлөх шимтгэл	5753135.4	7519331.0	7729860.0	-210529.7	7522367.9	9027152.6	860284.3	422868.3
Төсөвт байгууллагын төлөх шимтгэл	3450842.2	4511932.7	5698847.3	-1186914.6	5029564.0	2545991.1	6094909.9	-3548918.89
Сайн дурын даатгуулагчийн төлөх шимтгэл	899355.5	1670119.5	1502998.5	167121.0	1846886.8	2094363.5	2042723.7	51639.8
ҮОМШӨ-ий улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн	6609.6	10427.1	5506.2	4920.0	10427.1	9149.9	9103.5	46.4
ЭМД-ийн бусад даатгуулагчийн төлөх шимтгэл	0	465916.8	407464.1	58452.7	0	996532.1	565935.1	430597.0
Бусад орлого	1947320.1	35357.0	43083.1	-7726.10	62132.0	73577.7	56739.1	16638.0

Нөхөн шимтгэлийн орлого		1730736,0	1931031,6	-200295,0	.	.	.	
Нийт орлого	15363912,4	18657701,9	21077580,5	-2419878,6	17857224,2	21872719,4	21891752,3	-19032,9

Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуулиар нийгмийн даатгалын 5 санд 18657701.9 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 21077580.5 мянган төгрөгийн орлого хуримтлуулж төлөвлөгөөг 2419878.6 мянган төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Хүснэгтээс харахад даатгуулагчийн төлөх шимтгэл дийлэнх хувийг эзэлж байна.

Сангуудын орлого, зарлагын тайлангийн төсвийн гүйцэтгэлийг авч үзвэл

Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2021 онд нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг 16415264.0 мянган төгрөгөөр төлөвлөж, 18690494.0 мянган төгрөгийг төвлөрүүлэн төлөвлөгөөг 13 хувиар давуулан биелүүлж ажилласан байна. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 4242459.6 мянган төгрөг, дээд шатны байгууллагаас 4 санд 25735388.7 мянган төгрөгийн санхүүжилт авчээ. Нийгмийн даатгалын сангуудын зарлагыг 42454565.8 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 44388999.6 мянган төгрөгийг зарцуулсан, 5792598.9 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй, дээд шатны ерөнхий дансанд 5125311.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2022 онд шимтгэлийн орлогыг 20793345.9 мянган төгрөгөөр төлөвлөж, 21259975.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 2.3 хувиар давуулан биелүүлж ажилласан, мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 5792598.9 мянган төгрөг, дээд шатны байгууллагаас 32168910.8 мянган төгрөгийн санхүүжилт авчээ.

Сангуудын зарлагыг 59397157.1 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 59117680.7 мянган төгрөг зарцуулсан байна. Оны эцэст 4847416.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй, дээд шатны ерөнхий дансанд 8964631.6 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

-Тэтгэврийн даатгалын сангийн зарлага буюу өндөр настны тэтгэвэр гүйцэтгэлээр 2021 онд 41297457.6 мянган төгрөг төлөвлөж, 41063342.8 мянган төгрөг, 2022 онд 56247987.4 мянган төгрөгөөр, төлөвлөж гүйцэтгэлээр 56182109.5 мянган төгрөг зарцуулагдаж, өмнөх оноос 15118766.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тэтгэвэр авагчдын тоо нэмэгдсэн, мөн Засгийн газрын 2022 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 63 дугаар тогтоолын дагуу тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлж олгосонтой холбоотой байна.

- Тэтгэмжийн даатгалын сангийн зарлагыг 2021 онд 1194615.1 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1846215.2 мянган төгрөг олгогдсон, 2022 онд 2139291.4 мянган

төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 2027587.1 мянган төгрөг олгогдсон ба өмнөх онтой харьцуулахад 181371.9 мянган төгрөгөөр буурсан байна.

- ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 2021 онд 232589.2 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 205527.7 мянган төгрөг, 2022 онд 239679.2 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 215211.9 мянган төгрөг олгогдож, 24467.3 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь аж ахуй нэгж, байгууллагууд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг жил бүр дээшлүүлж үйлдвэрийн осол буурсантай холбоотой. Тэтгэврийн хувийн хэргийг татаж авч шалгахад хууль, журмын дагуу тогтоосон байна.

- Ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэмж авах иргэдийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2021 онд 325 иргэн байсан бол 2022 онд 390 иргэн буюу 65 иргэнээр нэмэгдэж, гүйцэтгэлээр 836207.3 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 767303.7 мянган төгрөг олгогдсон байна. Энэ нь ковид -19 цар тахал өвчин гарсантай холбогдуулан уул уурхайн аж ахуйн нэгжийн ажилтнууд олноороо чөлөөлөгдсөн нөхцөл байдалтай холбоотой байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, өглөгийн талаар:

Тус хэлтэс нь 2021 онд төлбөртэй үйлчилгээний авлага 344093.2 мянган төгрөгийн, татаас санхүүжилтийн авлага 3769808.7 төгрөгийн авлагатай илэрхийлэгдсэн ба энэ нь ковид цар тахалтай холбогдуулан ажил олгогч, даатгуулагчийн санхүүгийн эрсдлийг бууруулах зорилгоор “Нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөлөөлт, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай” хууль батлагдсан бөгөөд тус хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор үүссэн авлага байна. 2022 онд 3769808.6 мянган төгрөгийн авлагатай. Үүнээс 53 хувийг уул уурхайн үйл ажиллагаа явуулж газраас авах авлага эзэлж байна. 2938692.7 мянган төгрөгийн авлага нь дээд шатны байгууллагаас авах авлага байна.

2021 онд 44497.3 мянган төгрөгийн өглөгтэй бөгөөд үүнээс төсөвт байгууллагад 81704.2 мянган төгрөг, 2022 онд 25704.1 мянган төгрөгийн өглөгтэй, үүнээс төсөвт байгууллагад төлөх өглөг 13800.0 мянган төгрөг, сайн дурын даатгуулагчдад 70912.9 мянган төгрөгийн өглөгтэй илэрхийлэгдсэн байна.

Нийгмийн даатгалын шимтгэлд хяналт шалгалт, дотоод аудит хийсэн талаар:

Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийг 2022 онд шинэчлэн байгуулсан ба 2022 онд 3-н чиглэлийн дагуу 19 ажлыг төлөвлөсөн байна. Тус тасаг нь хяналт-шинжилгээ, үнэлгээ болон Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, хяналт шалгалтын төлөвлөгөөндөө байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь хамруулан төлөвлөж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар:

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор цахим хуудсанд холбогдох мэдээллийг мэдээлэх үүрэгтэй бөгөөд 2021 онд мэдээлвэл зохих 151 мэдээллээс 145 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, 5 мэдээлэлийн хугацаа хоцроосон, 1 мэдээллийг мэдээлээгүй, 2021 оны гүйцэтгэл 99.3 хувьтай байна. 2022 онд 150 мэдээллээс 140 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, 4 мэдээлэл хугацаа хоцроосон, 6 мэдээллийг мэдээлээгүй, 2022 оны гүйцэтгэл 97.3 хувьтай байна

Долоо: Шалгуулагчийн ололттой, дэвшилттэй тал:

Санхүүгийн үйл ажиллагааг ил тод нээлттэй ажиллуулж Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, аргачлал, журмын дагуу хийж гүйцэтгэж иржээ.

Түүнчлэн аймгийн Төрийн аудитын газраас 2021, 2022 оны үйл ажиллагаанд зөрчилгүй санал дүгнэлт өгсөн ба, аймгийн Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн төсөвт байгууллагуудыг дүгнэсэн дүнгээр “Тэргүүн” байр эзэлсэн байна.

Найм :Шалгалтаар илрүүлсэн нийтлэг зөрчил, дутагдал, шалтгаан түүнээс гарч болзошгүй буюу гарсан хохирол, хууль, тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт:

1.Тус хэлтэс нь 2022 онд татварын цахим системд бүртгэгдээгүй, И баримтаар баталгаажаагүй 16 удаагийн 3534.5 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1-д “албан татвар төлөгчийн хийсэн төлбөр тооцооны мэдээллийг хэрэглэгчийн системд төлбөр хийсэн тухай бүр бүртгэнэ”, 17.3.2-д “ бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”, 17.6-д “ Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй” гэсэн заалтуудтай,

2. Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2019 оны 05 сарын 10-ны өдрийн А/05 тоот тушаалаар батлагдсан Хөдөлмөрийн дотоод журмын 7.1.8 дахь заалтын дагуу Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын эмэгтэйчүүдэд дэмжлэг гэж 2021 онд 440.0 мянган төгрөгийн, 2022 онд 720.0 мянган төгрөг тус тус зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай,

хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6-д “ Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын тэмцээн, салбарын алдар, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

3. Тус хэлтсийн албан хаагчдын цалин тогтоолт, олголтыг тулган шалгахад Нийгмийн даатгалын улсын байцаагч Ц.Доржцэдэвт төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 402.3 мянган төгрөгийг дутуу олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг зөрчсөн.

4. Сайн дураар даатгуулагчдын шимтгэлийн алдангийг Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ аваагүй, байцаагч өөрөө ногдуулж, даатгуулагчаар төлүүлэх арга хэмжээ авч ажиллаж байгаа нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Тооцооны алдаа гаргаснаас шимтгэлийг дутуу төлсөн бол дутуу төлсөн шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс тооцооны алдаа гарснаас хойших хугацааны хоног тутамд 0,1 хувийн алданги ногдуулах ба алдангийн нийт хэмжээ дутуу төлсөн шимтгэлийн 30 хувиас хэтрэхгүй байна”, мөн хуулийн 20 дугаар зүйлийн 20.4-д “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ”, Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10.17.3-д “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нь нийгмийн даатгалын шимтгэлийг эрх бүхий байгууллагын тогтоосон хугацаанд төлөөгүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Ес: Авсан арга хэмжээ, мэргэжлийн туслалцаа, зөвлөгөө өгсөн байдал:

Тус хэлтсийн дарга, нягтлан бодогч нарт шалгалтын удирдамжийг танилцуулж, санхүүгийн баримтуудыг хүлээн авч шалгалтыг эхэллээ.

Шалгалтын хугацаанд шалгалтаар гарч байгаа зөрчил дутагдлыг дарга, нягтлан бодогч, байцаагч нарт танилцуулж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөмж өгч ажиллав.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.8 дахь хэсэгт “хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулах” гэснийг үндэслэн шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, таслан зогсоох 402.3 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт, 4694.5 мянган төгрөгийн албан шаардлага тогтоов.

Арав. Шалгагдсан аж ахуйн нэгжид өгсөн дүгнэлт, шийдвэрлэвэл зохих асуудал:

Тус байгууллагын 2021, 2022 оны үйл ажиллагааны зорилго зорилт, хүний нөөцөд дотоод аудит хийхэд 2021, 2022 онд “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэсэн зорилт тавин, Нийгмийн даатгалын санг арвижуулах, хууль тогтоомжийг мөрдүүлэх, төрийн албан хаагчдын үүрэг ухамсар, ёс зүйг дээдлэх, өөрийн эрхэлсэн ажилдаа болон ажлын байранд шинэлэг дэвшилттэй зүйл нэвтрүүлэх, аливаа мэдээ мэдээллийг оновчтой хэлбэрээр хүргэх зэргээр төлөвлөгөө гарган, түүнийгээ хэрэгжүүлж ажилласан байна. Мөн сайн дурын даатгуулагчдийг нэмэгдүүлхийн тулд ахмад улсын байцаагчийг гэрээгээр авч ажиллуулан, 2022 онд гэхэд 5000 сайн дурын даатгуулагчтай болохоор зорилт тавин ажилласанаар 11 сарын байдлаар 400 гаруй даатгуулагч хамруулж, албан журмын даатгуулагчийн тоо өмнө оноос 300 даатгуулагчаар нэмэгдсэн байна.

2021, 2022 онд Төсвийн тухай хуулийн 16.5.2-д “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 41.1.2-д “Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах” гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажилласан байна.

Нийгмийн даатгалын 5 сангийн үйл ажиллагаанд тулган шалгалт хийсэн ба ажилгүйдлийн даатгалын сангаас 2021, 2022 онд ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэдийн төрийн албанд хэдэн жил ажилласан, ажилгүйдлийн тэтгэмжийн хувийг зөв тооцсон эсэхийг шалгахад тухайн даатгуулагчийн хувийн хэргийн анхан шатны баримтын бүрдэл хангалттай байна. Сайн дурын даатгалын алдангийг ногдуулах, төлүүлэхдээ Зөрчлийн тухай хуулийг мөрдлөг болгож ажиллах шаардлагатай байна.

Шилэн дансны хэрэгжилтийг шалгахад төсөв ба гүйцэтгэл, төсвийн орлого, байгууллагын өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрийн жагсаалт, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авч буй эрх бүхий этгээдийн жагсаалт зэрэг мэдээллүүдээ байршуулсан байна.

Тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд нийт 5096.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн ба зөрчлийг ангилахад нийт зөрчлийн 69 хувь буюу 3534.5 мянган төгрөг нь И баримтаар баталгаажуулаагүйгүй зөрчил, 3 хувь буюу 402.3 мянган төгрөг нь дутуу олгогдсон цалин хөлс, 28 хувь буюу 1160.0 мянган төгрөг нь үр ашиггүй зарцуулсан зардал тус тус эзэлж байна.

Арван нэг. Цаашид авах арга хэмжээний санал

Нийгмийн даатгалын Ерөнхий газарт:

1. Сайн дурын даатгуулагч даатгалын шимтгэлээ хугацаандаа төлөөгүй тохиолдолд алданги төлөх, мөн Зөрчлийн тухай хуулиар тавин нэгжтэй тэнцэх хэмжээний

төгрөгөөр торгуулж байгаа сангийн орлогод эерэг нөлөө үзүүлэх ч нөгөө талаар сайн дураар даатгуулагчдад хохиролтой байна. Түүнчлэн сайн дураар даатгуулагчдын сангийн батлагдсан төлөвлөгөөг таслахгүй тулд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтыг зөрчиж торгохгүйгээр зөвхөн алдангийг төлүүлж байгаа нь нийгмийн даатгалын байгууллагад сөрөг нөлөө үзүүлж байна. Иймд дээр дурдсан асуудлыг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал гаргаж, сайн дураар даатгуулагчдад аль болох эерэг нөлөөтэй байхаар зохицуулалтыг тусгаж өгөх;

2. Цалингийн нэмэгдлийг аймаг, суманд ялгавартай тогтоосныг жигд олгодог болох.

Хэлтсийн даргад:

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах;
2. Он дамжсан байгууллагад төлөх өглөгийг шуурхай барагдуулах, цаашид үндэслэлгүй авлага, өр төлбөр үүсгэхгүй байх;
3. Тээвэр шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсын явсан замын маршрут, километрийн заалттай нэг бүрчлэн тулган, үнэн зөв, бүрэн гүйцэд бүртгэж байгааг шалган, тооцоог сар бүр хийж хэвших, төсвийн хөрөнгийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах;
4. Илүү цагийн болон үр дүнгийн урамшууллыг хууль, журамд нийцүүлэн олгох;
5. Танай байгууллагад хийсэн хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар хүргүүлж буй энэхүү зөвлөмжийн дагуу хийж гүйцэтгэсэн арга хэмжээг албан бичгээр 2023 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанд ирүүлэх, шалгалтаар илэрсэн зөрчилд дүгнэлт хийж арилгах, давтан гаргахгүй байх.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА